



## ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 5/53

Улаанбаатар хот

### С.Цоггэрэлийг мэргэжилтэн-архивчийн албан тушаалд томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны Оюуны өмчийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөр, бүтцийг батлах тухай" А/123 дугаар тушаал, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 05/10352 тоот албан бичийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Самдан овогтой Цоггэрэлийг 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн Эрх зүй, хүний нөөцийн мэргэжилтний албан тушаалаас чөлөөлж, Зохиогчийн эрхийн хэлтсийн Мэргэжилтэн-архивчийн албан тушаалд томилсугай.

2. С.Цоггэрэлийн ажлыг хүлээлгэн өгч, ажил хүлээлцсэн тухай тэмдэглэлийг 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн дотор Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлэхийг Хяналтын хэлтсийн дарга /Д.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. С.Цоггэрэлийн ажлыг зохих журмын дагуу тэмдэглэл үйлдэн 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн дотор авахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д үүрэг болгосугай.

4. С.Цоггэрэлийн албан тушаалын цалинг төрийн захиргааны албан хаагч дэс түшмэл ТЗ-6 зэрэглэлийн V шатлал тогтоож, хоол, унааны нөхөн төлбөрийг холбогдох журмын дагуу тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Оюунцэцэг/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЭНХСҮХ

000757